



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Г

Г

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 2 /хоёр/ хуулийн этгээдэд “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан хуулийн этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдтэй зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

ГИШҮҮД

Г.ЧИНЗОРИГ

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
143 тоот тогтоолын
хавсралт



Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	Бат сүлжээ ХХК	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх	2025.06.27	2030.06.27
2	Тазкванг кэй эйч ХХК	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх	2025.06.27	2030.06.27

----- оОо -----